



ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ

Эрүүл мэндийн  
яам



Цус Сэлбэлт Судлалын  
Үндэсний Төв



Олон Улсын Цус Сэлбэлтийн  
Нийгэмлэг



Азийн Цус Сэлбэлтийн  
Холбоо

# ЦУСНЫ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОЛОЛТ АМЖИЛТ



Мэйл: [nctmmgl@gmail.com](mailto:nctmmgl@gmail.com)  
Утас: (976 – 11) – 70136504, 70112857  
Факс: (976 - 11) - 70112857

# Цусны албаны бүтэц зохион байгуулалт



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

*Эрүүл мэндийн яам*



*Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв*

**Баянзүрх цус цуглуулах төв  
/Суурин төв/**



**Сүхбаатар цус цуглуулах төв  
/2-р байр/**



**Дүнжингарав цус  
цуглуулах төв**



**ЦУСНЫ САЛБАР ТӨВҮҮД**

*/21 аймагт үйл ажиллагаа явуулж буй 26 цусны салбар төвүүд хамаарна/*

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ



Төвийн Ерөнхий  
захирал  
**Н.Эрдэнэбаяр**

Удирдлагын зөвлөл


Эрдмийн зөвлөл



Захиргаа,  
маркетингийн  
алба  
**Ч.Батболд**



Эрдэм шинжилгээ,  
мэдээллийн  
технологийн алба  
**Л.Өнөрбаяр**



Чанар, цусны  
аюулгүй  
байдлын  
алба  
**Т.Алимаа**



Санхүү  
бүртгэлийн  
алба  
**Ө.Бат-Эрдэнэ**




Сувилахуйн  
алба  
**Б.Өнөрцэцэг**

Инженер техник,  
үйлчилгээний  
тасаг



Донор зохион  
байгуулалтын тасаг  
**Ё.Улсболд**



Нэгдсэн  
лабораотрийн  
тасаг  
**М.Цэрэндэжид**



Цус, цусан  
бүтээгдэхүүн  
үйлдвэрлэлийн  
тасаг  
**Н.Халиун**

26 цусны салбар төвүүд



Цус  
Сэлбэлт  
Судлалын  
Үндэсний  
Төв

## Алсын хараа

Цус сэлбэлт судлалын чиглэлээр Азидаа тэргүүлэгч орнуудын жишигт хүрнэ.

## Эрхэм зорилго

Чадварлаг баг, дэвшилтэт технологи, инновацид тулгуурлан, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд оршино.

# БИДНИЙ БАХАРХАЛ



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ



**2017 онд**  
Эрүүл мэндийн  
байгууллагын лабораторийн  
чанар ба чадавхид тавигдах  
шаардлага **MNS ISO  
15189:2015** үндэсний  
баталгаажуулалт хийлгэсэн.



**2017 онд**  
Чанарын менежментийн  
тогтолцооны **MNS ISO  
9001:2016** стандартаар  
баталгаажуулалт  
хийлгэсэн.



**2018 онд**  
Хөдөлмөрийн эрүүл мэнд,  
аюулгүй байдлын  
удирдлагын тогтолцоог  
хэрэгжүүлж, үндэсний  
хэмжээнд  
баталгаажуулалт  
хийлгэсэн.



**2018 онд**  
Хөдөлмөрийн эрүүл мэнд,  
аюулгүй байдлын удирдлагын  
тогтолцоо **OHSAS  
18001:2007/MNS OHSAS  
18001/2012** стандартын  
шаардлын дагуу  
баталгаажуулалт хийлгэсэн.



**2019 онд**  
Англи улсад төвтэй “Lloyd’s  
Registry” чанарын  
баталгаажуулалтын олон  
улсын байгууллагын  
хөндлөнгийн үнэлгээгээр **ISO  
9001:2015** баталгаажуулалт  
хийлгэсэн.

ЦССҮТ нь бүх үйл ажиллагаандаа дээрх стандартуудыг хэрэгжүүлсэн  
“Анхдагч эрүүл мэндийн байгууллага” юм.





# Олон улсын 3 стандарт хэрэгжүүлэгч байгууллага

- Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын магадлах аудит - 2019 оны 11 сарын 29-нд хийлгэсэн.
- Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо - Шаардлага MNS OHSAS 18001:2012 стандартын магадлах аудит - 2019 оны 12 сарын 02-нд хийлгэсэн.
- Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага MNS ISO 15189:2015 стандартын магадлах аудит хийлгэсэн.





# Олон улсын байгууллагаар Чанарын гадаад үнэлгээг амжилттай хийлгэсэн.

ЦССҮТ 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааныхаа хөтөлбөрт АХБ-ны ЭМСХХ-5 төслийн дэмжлэгтэйгээр Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын баталгаажуулалтыг гадаадын байгууллагаар хийлгэх зорилтыг тусгасан. Энэ хүрээнд:

- 2019 оны 1 дүгээр сард Англи улсын “Lloyd’s Registry” компанийн төлөөлөгч ирж ЦССҮТ-ийн нөхцөл байдалтай танилцаж, үнэлгээ хийсэн.
- 2019 оны 5 дугаар сард хоёрдугаар шатны давтан үнэлгээ хийгдэж, ЦССҮТ-ийн хамт олныг чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлж, нээлттэй ажиллаж чадаж байгааг тэмдэглээд 2019 оны 06 сарын 14-нд гэрчилгээгээ гардан авсан.




# Төвийн хэмжээнд мөрдөж, хэрэгжүүлж ажилласан бодлогын баримт бичиг



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

1. Төвийн дунд хугацааны хөгжлийн стратеги 2017-2020;
2. Төвийн дунд хугацааны маркетингийн хөтөлбөр 2017-2021;
3. Төвийн Чанарын хөгжлийн хөтөлбөр 2018-2023;
4. “Хүний нөөцийн хөгжил болон ажилтны нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр” 2018-2022;
5. Сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр 2018-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээ;
6. Мэдээллийн технологийн хөгжлийн бодлого 2019-2025;
7. “Аюулгүй ажлын байр-Ажилтны эрүүл мэнд хөтөлбөр” 2017-2019;
8. “Эрүүл төв” хөтөлбөр;
9. “Шилэн төв” төсөл.







# Тушаалын шинэчлэл

**2015  
(A/194)**

Цусны албаны үйл ажиллагаанд мөрдөж байгаа ЭМС-ын 2015 оны A/194, 2016 оны A/01, A/02 тоот тушаалыг шинэчлэх ажлыг хийсэн.

**2016  
(A/01)**

Тушаалыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг Төвийн захирлын 2019 оны A/39 тоот тушаалаар 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, тушаалын төслийг төвийн хэмжээнд ажлын хэсэг нийт 10 удаа хуралдаж, хэлэлцсэн. ЦСТ-үүдээс 1 удаа албан бичгээр саналыг ил тод хүлээн авч ажилласан.

**2016  
(A/02)**

Тушаалын төслийг 2019 оны 11 сарын 29-ны өдөр ЭМЯ-нд хүргүүлсэн. Шинэ тушаалын төсөл Цусны албаны үндсэн үйл ажиллагаанд мөрдөх 7 хавсралтаас бүрдэнэ.



# Төвийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдсэн онцлох ажлууд

01

Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэх, байнгын донорын тоог нэмэгдүүлэхэд сургалт, сурталчилгааны олон талт хэлбэрийг ашиглаж ажилласан.



1. 25 MN телевизийн “Танайд хоноё” нэвтрүүлэгт “Хүндэт донор” Ц.Өрнөхбаяр оролцсон. Сошиал, Youtube –д тавигдснаар 1,500 гаруй шейр, 6,500 хүн үзсэн байна.



2. МҮОНРТ-ийн “2019 оны Энэрэнгүй үйлстэн” тодруулах 1 сарын хугацаатай зохион байгуулагдсан нэвтрүүлэгт “Хүндэт донор” О.Ганбаяр оролцож Энэрэнгүй үйлстэн батламж гардан авсан.



- ETV-ийн телевизийн Эрүүл монгол хүн нэвтрүүлгийн “Зочинтой ярилцах цаг”,
- Монгол HD телевизийн “Өглөөний хүн” нэвтрүүлэг,
- MNB-ийн “Өглөөний зочин”, “Хүмүүнлэгийн үйлстэн” зэрэг нэвтрүүлэгт тасгийн ажилтан, хүндэт доноруудыг оролцуулсан.



# Төвийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдсэн онцлох ажлууд

## 02 Талх чихэр ХК – ийн санхүүжилтээр “Аз жаргалын мод” төслийг хэрэгжүүлсэн.



## 03 КоллПро /Callpro/ ухаалаг утасны үйлчилгээг нэвтрүүлсэн.



Байгууллагын утсанд ирсэн дуудлага бүрт мэдээлэл хүргэж, тохирох ажилтнуудтай холбосноор үйлчилгээний чанараа сайжруулж чадсан. Иргэдэд шуурхай үйлчлэх, төрийн үйлчилгээг цахимжуулах ажилд бодитоор ахиц гаргах боломжийг бүрдүүлсэн.

## 04 Соронзон кодтой чоож суурилуулсан.



Сүхбаатар цус цуглуулах төвийн гамшиг онцгой байдлын үеийн нөөц төвийн орох гарах хэсгийн хаалганд соронзон кодтой чоож суулгаснаар зөвшөөрөгдсөн эмч, мэргэжилтнүүд чип ашиглаж гадны хүн орж гарах урсгалаас 100% хамгаалах хаалттай болсон.



# Төвийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдсэн онцлох ажлууд

## 05 “Хур” төрийн мэдээлэл солилцооны системийг нэвтрүүлэхээр гэрээ байгуулан, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Уг системийг нэвтрүүлснээр иргэд, доноруудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд бичиг баримтаа авчраагүй тохиолдолд үйлчилгээ авах боломжгүй нөхцөл үүсэх, цусаа өгч чадахгүй байх зэрэг олон бэрхшээлүүдийг шийдвэрлэнэ.

Мөн “Иргэний үнэмлэхний мэдээлэл болон иргэний хаягийн мэдээлэл дамжуулах сервис”-т холбогдсоноор цусны донорын нууцлалыг хадгалах, сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, гамшиг онцгой байдлын үед донорын мэдээллийн сан үүсгэх, цусны аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

## 06 Цусны албаны “Хүндэт тэмдэг”-ний загварыг шинэчилсэн.





# Төвийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдсэн онцлох ажлууд

## 07 Төвийн дотоод аудит өргөн хүрээнд ажиллаж, чанаржиж байна.

2019 онд үйл ажиллагаандаа Чанарын менежментийн чиглэлээр 7, ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны чиглэлээр 2, Лабораторийн чиглэлээр 1, Санхүүгийн чиглэлээр 3 **нийт 13 удаа дотоод аудит хийж** сайн зүйлс, сайжруулах зүйлсийг тодорхойлон үйл ажиллагаагаа байнга сайжруулан ажиллаж байна.

## 08 “Амьдрал бэлэглэе” төслийн 10 жилийн ойн хүрээнд “Цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээний талаарх өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдвээр хэлэлцүүлэг хийсэн. Хэлэлцүүлэгт:

- МУ-ын хүний гавьяат эмч, АУ-ны доктор, профессор О.Сэргэлэн “Элэг шилжүүлэн суулгах хагалгааны үеийн цус цусан бүтээгдэхүүний хэрэглээ, цаашдын чиг хандлага”;
- ЦССҮТ-ийн Чанар сонор сэрэмжийн албаны дарга АУ-ны магистр зөвлөх зэрэгтэй эмч Т.Алимаа “Цусны албаны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”;
- ЭХЭМҮТ-ийн МЭЭ-ний тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны магистр, дэд профессор Б.Ганбилэг “Эх барих, төрөлтийн үеийн цус цусан бүтээгдэхүүний хэрэглээ, цаашдын чиг хандлага”;
- ГССҮТ-ийн цусны эмч Оюунгэрэл “Гэмтлийн үеийн цус цусан бүтээгдэхүүний хэрэглээ, цаашдын чиг хандлага” сэдвүүдээр оролцсон.






# Төвийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдсэн онцлох ажлууд

## 09 Чатбот үйлчилгээг нэвтрүүлсэн.

Төвийн Facebook хуудсанд “**Messenger chatbot**” систем хөгжүүлэх ажлыг хийснээр хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл болон түгээмэл асуултуудад цаг алдалгүй хариу өгөх боломжийг бүрдүүлсэн.

## 10 Зөөврийн таблет, баркод уншигч нэвтрүүлсэн.

Цус цуглуулах үед цахим төхөөрөмж ашиглан донорын мэдээллийг богино хугацаанд зөв бүртгэх, цус өгөх үедээ донорууд цахим мэдээлэл авч цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх нөхцөл бүрдүүлсэн.



# Донор зохион байгуулалтын тасагт нэвтрүүлсэн шинэ технологи



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

**01**

**MCSR+ олон  
үйлдэлт цус  
цуглуулах  
технологи**

**02**

**Цус цуглуулах  
нэмэлт  
хүүдийний  
технологи**

**03**

**Аферезийн аргаар  
2 нэгж улаан эс  
цуглуулах  
технологи**



# Нэгдсэн лабораторийн тасагт нэвтрүүлсэн шинэ технологи



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ



ЦССҮТ-ийн Нэгдсэн лабораторийн тасаг нь MNS/ISO 15189:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

- 1 • Чанарын хяналтын лаборатори
- 2 • Халдвар илрүүлэх лаборатори
- 3 • Иммуногематологийн лаборатори



## Нэгдсэн лабораторийн тасагт нэвтрүүлсэн шинэ технологи

1. Нуклейн хүчил олшруулах технологи
2. Цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх бүрэн автомат шинжилгээ хийх технологи
3. Цус бүлэгнэлтийн бүрэн автомат шинжилгээ хийх технологи
4. Иммуногематологийн бүрэн автомат шинжилгээ хийх технологи
5. Нян судлалын бүрэн автомат шинжилгээ хийх технологи




# Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тасагт нэвтрүүлсэн шинэ технологи



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

- 01** Сийвэн ба ялтаст эсийн бүтээгдэхүүний эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлэх технологи /Intercept Blood System/
- 02** Сийвэнгийн бүтээгдэхүүнийг хурдан хөлдөөх технологи
- 03** Ялтаст эсийн өтгөрүүлэг ба улаан эсийн бүтээгдэхүүнийг рентген туяагаар шарах технологи /Best theratronics Raycell/
- 04** Улаан эсийн бүтээгдэхүүнийг глицеринжүүлэн хөлдөөж, хадгалах технологи /Haemonetic ACP-215 device/
- 05** Улаан эсийн бүтээгдэхүүнийг +2+6, -30-40 хэмд хадгалах технологи “Walk in room” хүйтэн өрөө






# Төвийн хамтын ажиллагаа



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

## Дотоод хамтын ажиллагаа

- Монголын улаан загалмайн нийгэмлэг
- Монголын донорын холбоо
- Төрийн болон ТББ
- “Зэвсэгт хүчний жанжин штаб,
- “Сэтгэлийн 1000 үйлс” ТББ
- “Улаанбаатар смарт карт” ХХК
- Бусад




## Гадаад хамтын ажиллагаа

- Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэг **/ISBT/**
- Азийн цус сэлбэлтийн холбоо **/AATM/**
- Шанхайн цусны төв **/Shanghai Blood Center/**
- Японы Улаан загалмайн нийгэмлэг **/Japanese Red Cross Society/**
- Дэлхийн гемофилийн холбоо **/World Federation of Hemophilia/**
- Азийн хөгжлийн банк **/Asian Development Bank/**




# Сар бүрийн 3-ны “Цусаа бэлэглэх өдөр”-ийг дараах байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгуулсан.

- |          |                                       |           |   |
|----------|---------------------------------------|-----------|---|
| 1<br>CAP | Цусны донорын үндэсний өдрийг JCI-тай | 7<br>CAP  | Монголын аялал зуучлалын холбоо                                       |
| 2<br>CAP | “Сэтгэлийн 1000 үйлс” ТББ             | 8<br>CAP  | “Жем Интернэшнл” ХХК  |
| 3<br>CAP | “Сод монгол” групп                    | 9<br>CAP  | “Улаанбаатар смарт карт” ХХК  |
| 4<br>CAP | JCI Капитал байгууллага               | 10<br>CAP | Худалдаа хөгжлийн банк  |
| 5<br>CAP | МУЗН болон “Санхими” ХХК              | 11<br>CAP | МУЗН, МУБИС болон МУБИС-ийн дэргэдэх Залуучуудын Улаан загалмай клуб, |
| 6<br>CAP | “Хувийн орон сууц аж ахуйн үйлчилгээ” | 12<br>CAP | “Жем интернэшнл” ХХК болон Монголын донорын холбоо                    |



# АХБ-ны ЭМХХ-5 төсөл “Цусны аюулгүй байдал” 2014-2019

Төсөл 2014 оны 7 сараас эхлэн 2019 оны 7 сарын 1 хүртэл нийт 5 жилийн турш доорх 4 чиглэлийн дагуу үргэлжилсэн. Үүнд:



Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилт **99.2%**-ийн гүйцэтгэлтэй гарсан.

# ЦЦБ-ий зохистой хэрэглээг сайжруулах чиглэлээр:

Хяналт, үнэлгээ:



- ТТАХНЭ, ХСҮТ, ГССҮТ, Амгалан амаржих
- 20 эмнэлэгт /бүтээгдэхүүн хадгалалт/

**УЛААНБААТАР ХОТОД**




- Дундговь,
- Ховд,
- Дархан уул,
- Өвөрхангай,
- Дорноговь аймаг

**ХӨДӨӨ ОРОН НУТАГТ**



Хяналт, үнэлгээний чиглэлээр Улаанбатар хот болон хөдөө орон нутагт байрлах дээрх байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



# Хүний нөөцийг сургах, ур чадвар эзэмшүүлэх


**Гадаад сургалт:** БНХАУ-ийн Шанхай хотын цусны төв, Камбожи улс, ОХУ-ийн Улаан-Үүд цусны төв, Тайланд улсын Бангконг, Япон улсуудад нийт давхардсан тоогоор **16** эмч, мэргэжилтнүүдээ богино болон урт хугацааны сургалтад хамруулсан.

**Дотоод сургалт:** Эмч, мэргэжилтнүүдийнхээ мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор ЭМЯ, ЭМХТ болон холбогдох мэргэжилийн дагуу зохион явуулсан **45 чиглэлийн сургалтуудад** давхардсан тоогоор **74 эмч, мэргэжилтнээ** хамруулж сургасан байна.

Нийт ажилтны дотоод тасралтгүй сургалтыг тогтмол явуулж 23 удаагийн сургалт зохион байгуулснаас ХЭМАБ, Ёсзүй харилцаа хандлага сэдэвт сургалтуудыг 15 удаа зохион явуулж эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилтан нийт **давхардсан тоогоор 846 хүн хамрагдсан байна.** Мөн шинээр ажилд орсон ажилчиддаа баримжаа олгох сургалтыг зохион явуулдагаас энэ жил 3 удаагийн сургалтаар 25 хүнийг сургалтад хамруулсан байна.



# Цусны албаны үндсэн үйл ажиллагааны статистик мэдээлэл /нийт цус цуглуулалт/



Сүүлийн 5 жилийн байдлаар Цусны албаны хэмжээнд нийт цус цуглуулалтын тоо 2015 онд 30396 байсан бол 2019 онд 34956 болж **15 хувиар өссөн** үзүүлэлттэй байна.






# Цусны албаны үндсэн үйл ажиллагааны статистик мэдээлэл /ЦСТ-үүдийн цус цуглуулалт/



2019 оны байдлаар цус цуглуулалтын тоо Дорнод (619); Хөвсгөл (745); Дархан (807) зэрэг аймгуудад хамгийн өндөр байсан бол Говьсүмбэр (137); Говь-Алтай (187); Булган (187); Дундговь (188) зэрэг аймгуудад бага байна.




# Цусны албаны үндсэн үйл ажиллагааны статистик мэдээлэл /1000 хүн амд ногдох цус өгөлтийн тоо/



Цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ болон хүн амын тооноос шалтгаалан хөдөө орон нутагт 1000 хүн амд ногдох цус цуглуулалтын тоо сүүлийн жилүүдэд тогтмол үзүүлэлттэй байна.




# Цусны албаны үндсэн үйл ажиллагааны статистик мэдээлэл /ЦСДХ илрүүлэх шинжилгээгээр хасагдалт/



2015-2019 онд Цусны албаны хэмжээнд ЦСДХ илрүүлэх шинжилгээгээр хасагдалт 2 дахин буурсан үзүүлэлттэй байна.



# Цусны албаны үндсэн үйл ажиллагааны статистик мэдээлэл /ЦЦБ-ий үйлдвэрлэл/




2015-2019 онд Цусны албаны хэмжээнд ЦЦБ-ий үйлдвэрлэл **36% өссөн** үзүүлэлттэй байна.




# Төвийн үндсэн үйл ажиллагааны статистик мэдээлэл


Зураг 1. Нийт цус цуглуулалт



Зураг 2. Цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээгээр хасагдалт



Зураг 3. Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл







“Цусны 1000 донор” үндэсний чуулга уулзалтыг Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор амжилттай зохион байгуулсан.



## ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДӨР



2019 оны 6 сарын 14-ны өдрийг 15 дах жилдээ “Аюулгүй цус, цусан бүтээгдэхүүн: Хэнд ч, Хаана ч” гэсэн уриатайгаар Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “ЦУСНЫ 1000 ДОНОР”-ын Үндэсний чуулга уулзалт нэртэйгээр Төрийн ордны Их танхимд амжилттай зохион байгуулсан.





# Цусны Албаны Үндэсний Цахим Семинар




Цусны албаны эмч,  
мэргэжилтнүүд



2019 оны 03 сарын 28

Цусны албаны Үндэсний семинар 2019 оны 3 дугаар сарын 28-нд цахим хэлбэрээр болсон.

Энэ удаагийн семинараар Цусны салбар төвүүдийн 2018 оны ажлын тайлан, ололт амжилт, анхаарвал зохих асуудлуудыг хэлэлцэж, харилцан сайн туршлагаа солилцсон.



# Цус албаны лабораторийн эмч, мэргэжилтнүүдэд зориулсан “Чанарын гадаад үнэлгээний Олон улсын Workshop-ийг Монгол улсад анх удаа амжилттай зохион байгуулсан.

ЦССҮТ нь Монголд анх удаа 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр лабораторийн эмч, мэргэжилтнүүдэд чанарын менежментийн тогтолцоо, олон улсад хэрэгжиж буй чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн давуу тал, бэрхшээлийн талаар мэдлэг олгох зорилгоор БНХАУ-ын Шанхайн Цусны Төв болон Иран улсын цусны төвтэй хамтарсан “Чанарын гадаад үнэлгээний хөтөлбөр зохион байгуулах ач холбогдол, давуу тал, бэрхшээл” сэдэвт олон улсын сургалт, семинарыг амжилттай зохион байгуулсан.



# Азийн цус сэлбэлтийн холбооны XV их хурлыг Монгол улсад анх удаа амжилттай зохион байгуулсан.




Гадаадын 22 орны  
зочин төлөөлөгч



Монголын Цусны  
албаны 300 гаруй эмч,  
мэргэжилтнүүд

ЦССҮТ нь Азийн цус сэлбэлтийн холбооны XV их хурлыг Монгол улсад анх удаа 2019 оны 9 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд **"Өнөөдрийн амжилтаас Ирээдүйн дэвшил"** сэдвийн хүрээнд амжилттай зохион байгууллаа. Хуралд нийт гадаадын 22 орны зочин төлөөлөгч, Монголын Цусны албаны 300 гаруй эмч, мэргэжилтнүүд хамрагдсан.





# Гемофилийн мэдээллийн төвтэй болсон.

Тус төв нь өөрийн байранд гемофили өвчтэй хүмүүст зориулсан Гемофилийн мэдээллийн төвийн нээлтийг хийсэн.

Ингэснээр гемофили өвчтэй хүмүүс, тэдний эцэг, эх гэр бүлд сургалт хийж, мэдээллээр хангах, эрүүл мэндийн боловсролыг нь дээшлүүлэх, тусламж үйлчилгээг сайжруулах онцгой ач холбогдолтой юм.



# Сайн туршлагыг түгээж ажилласан.

**MNS OHSAS 18001:2012, ISO 9001:2015 стандарт, “Эрүүл аюулгүй ажлын байр эрхэмлэгч байгууллага”-ын сайн туршлагыг судлах, хэрэгжилттэй танилцах зорилгоор:**

- Хүрээ амаржих газар, Амгалан амаржих газар;
- Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв;
- Налайх дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс;
- Налайх дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төв;
- "Чимэг" хувийн эмнэлэг;
- Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс;
- Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургуулийн нийт 7 байгууллагын 100 гаруй эмч, мэргэжилтэн, оюутнууд хүрэлцэн ирсэн.



# Төвийн ажилчдыг гамшгаас хамгаалах сургалтад амжилттай хамруулсан.

НЗДТГ, ОБЕГ-тай хамтран зохион байгуулж буй Нийслэлийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилтанд хамрагдсан.







# “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар шалгарсан.

ХНХЯ, Хөдөлмөрийн эрүүл мэндийн үндэсний төвөөс зохион байгуулдаг “Эрүүл аюулгүй ажлын байр эрхэмлэгч байгууллага 2018” болзолт уралдаанд дунд аж ахуйн нэгжийн номинацад 2 дугаар байрт шалгарч 2019 оны 01 сарын 19-нд шагналаа гардаж авсан.



# Нийслэлийн Баянзүрх дүүргийн "2019 оны шилдэг эрүүл мэндийн байгууллага"-аар шалгарсан.

Тус төв нь 2019 оны ажлаараа нийслэлийн Баянзүрх дүүргийн "Оны шилдэг эрүүл мэндийн байгууллага"-аар шалгарсан.



# “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй Шилдэг эрүүл мэндийн байгууллага”-аар шалгарсан.

Төвийн нийт хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд болон төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй donоруудыг дэмжих боломжит бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.



Анхаарал хандуулсанд баярлалаа

---

*"Thank you for saving my life"*